



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 63

Мандалговь

□ Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах □  
зөвшөөрөл олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


Нэг. Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2018 оны 13-07-066/69 дүгээр дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 9,411,600 /есөн сая дөрвөн зуу арван нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийн балансын үнэтэй, 684,264 /зургаан зуун наян дөрвөн мянга хоёр зуун жаран дөрөв/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурдсан эмнэлгийн чулуун барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Т.Отгонзул)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах.
- 2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны... дүгээр сарын  
28-ний өдрийн 63-тогтоолын хавсралт

Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн акталж данснаас хасах барилгын мэдээлэл

№	Барилга, байгууламжийн нэр	зориулалт	Хэмжих нэгж		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Чулуун байшин	Амрах байр	M2	105	1978-01-01	60	9,411,600	8,727,335.29	684,264.71
<b>Нийт дүн</b>									
							9,411,600	8,727,335.29	684,267.71
							/есөн сая дөрвөн зуун арван нэгэн мянга зургаан зуун төгрөг/	/найман сая долоон зуун хорин долоон мянга гурван зуун гучин тав хорин есөн мөнгө/	/зургаан зуун наян дөрвөн мянга хоёр зуун жаран долоо далан нэгэн мөнгө/